



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IY байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.03.06 № 02112-VAH-CAH/2013/06-CTA-TT3

Улсын төсвийн орлого болгох тухай

Үндэсний аудитын газрын 2013 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Оюуны өмчийн газрын 2012 оны ажил, үйлчилгээний орлогыг улсын төсөвт бүрэн төвлөрүүлсэн эсэхийг шалгахад мөнгөн гүйлгээний тайлангаар 623,474,403.29 төгрөгийн орлого орсноос, улсын төсөвт 604,490,000.12 төгрөгийг шилжүүлж, 18,984,403.17 төгрөгийг дутуу төвлөрүүлсэн зөрчил дутагдал илэрлээ.

Энэ нь Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлд: "Монгол Улсын төсөвт 2012 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллага, бусад байгууллагын төвлөрүүлэх орлогын дүнг дор дурдсанаар баталсугай" гэснийг хэрэгжүүлээгүй байна.

"Төрийн аудитын тухай" хуулийн 15.1.12-д: ".....аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, Монгол улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 2.1.1-д: "төлвөл зохих төсвийн орлогыг дутуу төвлөрүүлсэн, эсвэл төвлөрүүлээгүй зөрчилд төрийн аудитын байгууллага акт тавина" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Дээр дурдсан зөрчил дутагдлын бүгд 18,984,403.17 төгрөгийг Үндэсний аудитын газрын Төв төрийн сангийн 900000601 тоот дансанд 2013 оны 06 дугаар сарын 1-ний дотор төвлөрүүлж, улсын төсвийн орлого болгох

2. Тогтоосон төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч, биелэлтийг 2013 оны 06 дугаар сарын 25-ны дотор УАГ-т ирүүлэхийг Оюуны өмчийн газрын дарга Н.Чинбат, Ерөнхий нягтлан бодогч Д.Чинчулуун нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН:

Үндэсний аудитын газрын
Аудитор И.Туяа

УХА0122

ЗӨВШӨӨРСӨН:

Оюуны өмчийн газрын дарга
Н.Чинбат

Ерөнхий нягтлан бодогч
Д.Чинчулуун

070031